



МОНГОЛ УЛС  
ХЭНГИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2018 оны 02 сарын 06 өдөр

Дугаар А/35

Хэрлэн сум

Урамшуулал олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.1.3-ын "а", Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.2, 58.2.1, 58.2.17, Сангийн сайдын 2012 оны 239 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийг зориулалт, зарцуулалтын журам"-ын 2 дугаар зүйлийн 2.1.3 дахь заалтууд, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2018 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. 2015 оны 5 дугаар сарын 19-ний өдрийн А/251 дүгээр захирамжаар батлагдсан "Энгийн болон нүхэн зорь барьсан ногоочдын бүлэг, иргэд, хоршоо, нөхөрлөлд урамшуулал олгох тухай журам"-ын дагуу Дадал сумын иргэн Дамбын Мягмар, Цэнхэрмандал сумын "Цэнхэрийн Ундраа" хоршоо, Хэрлэн сумын иргэн Амарсайханы Пүрэвдорж нарт урамшуулал олгосугай.

2. Урамшуулалд шаардагдах 3000000 /гурван сая/ төгрөгийн хөрөнгийг аймгийн Засаг даргын нөөц сангийн болзошгүй зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /С.Нямдаваа/-д, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Ж.Ганбаатар/-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА